



ДУНДГОВЬ АЙМАГ
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 07 өдөр

Дугаар А/232

Мандалговь

Сумын 2021 оны газар зохион байгуулалтын
төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг
байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын “б” дахь заалт, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.2 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.4.1 дэх заалт, 25 дугаар зүйлийн 25.1.4, 25.4 дэх заалт, 52 дугаар зүйлийн 52.2 дахь заалт, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2010 оны 497 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Сумын 2021 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Газрын даамал
Гишүүд:	Багийн Засаг дарга нар Байгаль орчны хяналтын улсын байцаагч Хөдөө аж ахуйн тасгийн дарга

Хоёр. Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг холбогдох журмын дагуу боловсруулж, Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж ажиллахыг ажлын хэсгийн гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.БАТ-ОРГИЛ